



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 187

Номгон

Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2011 онд Монгол Улсад орж ирсэн 19,000,000 төгрөгийн анхны үнэтэй элэгдлээ 100 хувь нөхсөн УАЗ-220692 маркийн 12-08БНХ улсын дугаартай автомашины худалдах доод үнийг 2000000 /хоёр сая/ төгрөгөөр, Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2010 онд Монгол Улсад орж ирсэн 18,500,000 төгрөгийн өртөг бүхий УАЗ-220692 маркийн 51-00БНА улсын дугаартай автомашины худалдах доод үнийг 500000 /таван зуун мянган/ төгрөгөөр тус тус тогтоож нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай.


2.1 Автомашины нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 11⁰⁰ цагт Аймгийн Засаг даргын Тамгын газрын 103 тоот өрөөнд зохион байгуулж орлогыг Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэх.

2.2. Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-д бүртгэх.

2.3. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2020 оны 06 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх.

119017

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР